МОНГОЛ УЛС
УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас: 7045-2315, Факс: 7045-4095
Цахим шуудан: info@uvs.gov.mn
Цахим хуудас: www.uvs.gov.mn

2025.12.23 № 2/2013

танай __________ -ны № ______________ -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ
ТАНАА

Тодорхойлолт хүргүүлэх тухай

Увс аймгийн Зүүнговь сумын харьяат, ахмад уран бүтээлч агсан, Монгол Улсын Гавьяат жүжигчин Эжээгийн Тойвгоо нь 1966 оноос хөөмийн урлагийг анхлан сурсан үеэс эхлэн эдүгээ хүртэл 57 жилийн турш Монгол хөөмий, түүнийг дэлхий дахинаа сурталчлан таниулах, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх, хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулахад оруулсан хөдөлмөр зүтгэл, санаачилгыг нь үндэслэн Монгол улсын Засгийн газрын 2018 оны 354 тогтоолоор батлагдсан журмын дагуу “Соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид” дахин нэр дэвшүүлж байна.

Монгол Улсын Гавьяат Жүжигчин Эжээгийн Тойвгоо нь өвчний улмаас 2025 оны 3 дугаар сард таалал төгсөж бид бүхэнд нөхөж баршгүй хүнд гарз тохиосон билээ.

Иймд Увс аймгаас нэр дэвшүүлж буй МУГЖ агсан Э.Тойвгоог шилдэг өвлөн уламжлагчаар дэмжин хамтран ажиллана уу.

Хавсралт 32 хуудастай

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Э.БААТАРСАН

D:\АЗДТГ\zasag A4.docx

85 507 1061

УВС АЙМГИЙН
СОЁЛ,УРЛАГ,АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85169
Утас: 7045-2278
Цахим шуудан: soyol@uvs.gov.mn

2025.12.23 № 221

танай ____________ -ны № ______________ -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ ТАНАА

Увс аймгийн Зүүнговь сумын харьяат, Монгол Улсын Гавьяат жүжигчин Эжээ овогтой Тойвгоо агсан 1966 оноос хөөмийн урлагийг анхлан сурсан үеэс эхлэн 57 жилийн турш Монгол хөөмий, түүнийг дэлхий дахинаа сурталчлан таниулах, ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгүүлэх, хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулахад оруулсан хөдөлмөр, хичээл зүтгэл, санаачилгыг үндэслэн соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид нэр дэвшүүлж байна.

Иймд Увс аймгаас нэр дэвшүүлж буй МУГЖ Э.Тойвгоо агсаны шилдэг өвлөн уламжлагчаар дэмжин хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт ..... хуудастай.

4024346 1524100007

ДАРГА Т.ОЮУНЦЭЦЭГ

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible] :
[illegible] : soyol@uvs.gov.mn
[illegible] : 7045 2278
3 [illegible] · 85169
[illegible]

# ЭЖЭЭ ОВОГТОЙ ТОЙВГООГИЙН АЖИЛ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Увс аймаг Улаангом сум. 2025.12.23

Эжээ овогтой Тойвгоо нь 1957 онд Увс аймгийн Зүүнговь суманд төрсөн. Бага насаа эцэг эхийн дэргэд өсөж, 1965 онд Зүүнговь сумын дунд сургуульд суралцаж 4 дүгээр ангийн боловсрол эзэмшиж, 1966 оноос мал дээр гарч эцэг эхдээ тусалж байгаад 1975-1978 оны хооронд цэргийн алба хаасан. Малын бэлчээрт явахдаа магнетфоноор хөөмий сонсож, дагаж дуугарсаар хөөмийлж сурсан.

1980 онд Бүх ард түмний урлагийн их наадамд оролцож, хөөмийн төрлөөр шалгарснаар аймгийн Хөгжимт драмын теарт уригдан хөөмийчнөөр ажиллах болсон. Үүнээс хойш Увс аймгийн Хөгжимт драмын театрт 28 жил тасралтгүй ажилласан.

Тэрээр ажиллаж байх хугацаандаа өөрөө үгийн бичиж ая хийсэн “Буурал тохой нутаг” магтаалын олны хүртээл болгож, “ Хэнтийн өндөр ууланд”, “Сэргэвэр хадны зэрэглээ”, “Сийлэн бөөр”, “Гоож нанаа”, “Хонин жороо морь”, “Могой хээр морь”, “Гунан хар”, “Арван тавны сар”, Судгийн ногоон”, Хотгойдын унага”, “Буянт гол”, Шилийн даваа”, “Тэмээн дээрээс наран ойрхон”, “Аман хуур”, “Богд дүнжингарав”, “Таван настай халиун”, Үглээ шаазгай”, “Говийн өндөр”, “Хүрэн хаалгатай дэлгүүр”, “Дөрвөн уул” зэрэг 20 гаруй Монгол ардын дууг хөөмийлж, “Буурал тохой ” магтаал, Монгол ардын дуу “Дөрвөн уул”-ыг дүрсжүүлж, “Алтай хайрхан” нэртэй CD гаргасан. Театрынхаа уран бүтээлчид болон шавь нартайгаа хамтран өөрийн бие даасан “ХАНХӨХИЙН ЦУУРАЙ”, “ГОВЬ ХАНГАЙ ЦУУРАЙН ЭГШИГЛЭН”, “ХӨӨМИЙН ЦУУРАЙ”, “УВСЫН ЦЭНХЭР ХЯЗГААР” зэрэг том хэмжээний тоглолтууд зохион байгуулж, дотоодын аялан тоглолтоор Монгол Улсынхаа 3 хот, 21 аймаг, 300 гаруй суманд явж, 1500 гаруй удаагийн тоглолтод 500000 гаруй үзэгчдийг хамруулан, үзэгчдийн таашаал хүртэж, 2-3 удаа дахиулахаас нааш оруулдаггүй байсан байна. Зөвхөн хөөмийлөхийн зэрэгтэй “Цацал”, “Түүх мартахгүй” зэрэг баримтад кино, “Сүнжидмаа”, “Учиртай гурван толгой”, “Ээрэм хүрээ”, “Хөх торгон дээл” зэрэг түүхэн жүжигт дүр бүтээж байсан.

Мөн язгуур урлагийн гайхамшгийг дэлхийн 20 гаруй улс оронд сурталчилж авьяас, хоолойн чадал, гайхамшигт дуугаралтыг шүтэн биширч, 1987 онд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад Монголын сурталчлах өдрүүдийн үеэр Э.Тойвгоог Төрийн ордондоо урин залж Хо Ши Мин хотын “Хүндэт иргэн”, “Соёлын тэргүүн” цолоор шагнаж алдаршуулсан байдаг. 1991 онд Монгол улсын “Соёлын тэргүүний ажилтан”, 2001 онд Монголын хөөмийн холбоооос Баруун монголын “Алдарт хөөмийчин”, хөөмийн “Амьсгааны хаан” хэмээх цол чимэг авч байсан.

Хөөмийн үндсэн дуугаралтыг “Хархираа, Харгиа” хөөмийгөөр баяжуулсныг хөөмий судлаачид өндрөөр үнэлдэг төдийгүй, битүү амьсгаагаар монгол ардын дууг 3 бадаг хөөмийлж, Монголын биет бус өвийг тээгч, олон шавь нартаа өвлөн уламжлуулсан гавьяаг Монголын төр үнэлж 2001 онд Монгол Улсын “Гавьяат жүжигчин” цол тэмдгээр шагнасан.

Соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр Монгол Улсын нэрийн өмнөөс хөөмийн урлагийг төлөөлөн гадаадын Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Камбожийн Хаант Улс, Япон Улс, Оросын Холбооны Улс, Франц Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Финланд Улс зэрэг 20 гаруй орноор аялан тоглолт хийсэн.

Монгол түмний үндэсний уламжлалт хөөмийн битүү амьсгааны өвийг өвлөж, түгээн дэлгэрүүлэх, залуу хойч үедээ өвлүүлэх үйлст оруулсан хөдөлмөр, зүтгэл, гавьяаг үнэлж 2012 онд “Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын Билэг авьяастнуудын Улсын жагсаалт”-д бүртгэж “Батламж” олгосон. Тэрээр Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийн Үндэсний жагсаалт"-д бүртгэгдсэн 102 өвлөн уламжлагчийн нэг юм.

Эжээгийн Тойвгоо нь 2010 онд ЮНЕСКО-гийн Соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад “Монголын уламжлалт Хөөмэйн урлаг”-ийг бүртгүүлэхэд дуу, дүрсний бичлэгт орох, судлаачдын судалгааны ажилд мэдээлэл өгөх, БНХАУ, ОХУ-ын Тува Улсын хөөмийчдөөс ялгарах хөөмийн “БИТҮҮ АМЬСГАА”-ны гайхамшгийг дэлхий дахинд сурталчлах, хөөмийг Монголын өв гэж батлахад голлох үүрэгтэй оролцож, бодитой хувь нэмэр оруулсан.

1981 онд ОХУ-ын Тува Улсын Кызыл хотноо зохион байгуулсан Ардын Урлагийн наадмын шилдэг үзүүлбэрийн Тэргүүн байрын шагнал хүртсэн.

1987 онд БНАСАУ-ын удирдагч асан Ким Ир Сений 75 насны ойд уригдсан цөөхөн авьяастнуудын нэгт Э.Тойвгоо багтаж, БНАСАУ-ын Пхеньян хотын Хаврын баяр урлагийн наадмаас Алтан медаль хүртсэн.

1992 онд ОХУ-ын Тува Улсын Кызыл хотод зохион байгуулагдсан олон улсын хөөмийчдийн уралдаан оролцож, 150 гаруй хөөмийчдөөс тэргүүн байр эзэлж, удаах байрыг түүний шавь Ж.Сундуй хүртсэн.

2000 оноос хойч үедээ өвлүүлэх шавь сургалт зохион явуулсан бөгөөд аймгийнхаа 12 сумын 200 гаруй хүүхдийг хамруулсан байна.

Шавь нарын гаргасан амжилтуудаас:

- **Аюушийн Лхагва:** Монгол Улсын Тэргүүний ардын авьяастан. Язгуур урлагийн хошой Алтан медальт, Хөөмийчдийн наадмын Мөнгө, Хүрэл медальт, Франц, Америкт зохион байгуулагдсан 36, 37 дугаар фестивальд хөөмийн төрлөөр уригдаж оролцсон.
- **Жүгнээн Сундуй:** МУТАА, Тэс сумын малчин. 1992 онд ОХУ-ын Тува Улсын Кызыл хотод зохион байгуулагдсан хөөмийчдийн уралдааны Мөнгөн медальт

- **Дамдинсүрэнгийн Басан:** Ойрад ХЖТ-ын хөөмийчин МУСТА Д.Басан хөөмийний онцлог битүү амьсгааг төгс эзэмшиж, 2010-2014 онд СУИС-ийн Монгол хөөмийний ангийг дүүргэн, 2015 оноос Увс аймгийн Ойрад Хөгжимт Жүжгийн театрт өнөөг хүртэл ажиллаж байна. Монголын болон ОХУ-ын Улан-Удэ, Тува Улсад зохион байгуулагдсан хөөмийчдийн олон улсын чанартай наадамд оролцон "Тусгай", "Тэргүүн", "Шилдэг хөөмийч" "Гранпри" шагналуудыг хүртэж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөөмийч болохоо харуулж чадсан. Ажлынхаа хажуугаар хөөмийн шавь сургалт зохион байгуулж, одоогоор 100 гаруй хүүхдэд хөөмийг эзэмшүүлсэн байна.
- **МУСТА Лхамсүрэнгийн Лхамрагчаа:** ҮДБЭЧ-д хөөмийчнөөр ажиллаж байсан. Одоо бие даан уран бүтээлээ туурвиж байгаа, 2008 онд Улсын ерөөлт магтаалчдын 6 дугаар уралдааны 2-р байр, 2009 оны Олон улсын Монгол хөөмийн симпозиумаас хамтлагаараа 1-р байр, "Алтай хайрхан" хамтлагтай Европын 10 гаруй орноор айлчлан тоглолт хийсэн. Ажлынхаа хажуугаар хөөмийн шавь сургалт зохион байгуулж, одоогоор 340 гаруй хүүхдэд сургасан байна.

Э.Тойвгоо нь нийтдээ өөрийн болон шавийн хамтарсан 640 гаруй хөөмийчин бэлтгэсэн байна.

Оролцож байсан сургалт, нэвтрүүлэг, судалгааны ажлын линк:

- (82) E. Toivgoo - Э. Тойвгоо / An Anthology of Mongolian Khöömii - Монгол Хөөмийн Сонгомол - YouTube
- (82) Naaraan suutn E Toivgoo 2016 - YouTube
- https://www.facebook.com/enkhlen.pagvajav/videos/1478539272236152
- (82) O. Otgonkhüü - О. Отгонхүү / An Anthology of Mongolian Khöömii - Монгол Хөөмийн Сонгомол - YouTube
- (82) Хөөмийч Л.Лхамрагчаа - "Жангар" тууль - YouTube
- (82) Таван тэсийн магтаал | Хөөмийч Д.Басан | Ойрад театр | Бидний цөөхөн Монголчууд - YouTube
- https://www.youtube.com/watch?v=7Gat6f4UdwA

Иймд МУГЖ, хөөмийчин Э.Тойвгоо агсаны Монгол хөөмий, түүнийг дэлхий дахинаа сурталчлан таниулахад оруулсан хөдөлмөр, хичээл зүтгэл, санаачилгыг үндэслэн соёлын биет бус өвийг сурталчлан алдаршуулах, түгээн дэлгэрүүлэхэд онцгой хувь нэмэр оруулсан өвлөн уламжлагчид нэр дэвшүүлж байна.

УВС АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
ГАЗРЫН ДАРГА Т.ОЮУНЦЭЦЭГ

4024346 1524100007

## ЭЖЭЭ ОВОГТОЙ ТОЙВГООГИЙН АМЖИЛТУУДААС:

| № | Оролцсон наадам, гавьяа шагнал | Он |
|---|---|---|
| 1 | Монголын Бүх ард түмний урлагийн үзлэгийн Тэргүүн байр | 1980 |
| 2 | ОХУ-ын Тува Улсын Кызыл хот Ардын Урлагийн наадмын шилдэг үзүүлбэрийн Тэргүүн байрын шагнал | 1981 |
| 3 | Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хо Ши Мин хотын “Хүндэт иргэн”, “Соёлын тэргүүн” цол тэмдэг | 1987 |
| 4 | БНАСАУ-ын “Хаврын баяр” урлагийн наадмын Алтан медаль | 1989 |
| 5 | Монгол Улсын “Соёлын тэргүүний ажилтан” цол тэмдэг | 1991 |
| 6 | ОХУ-ын Тува Улсын Кызыл хот, олон Улсын хөөмийчдийн уралдааны Тэргүүн байр | 1992 |
| 7 | Монголын хөөмийн холбооноос Баруун монголын “Алдарт хөөмийчин”, хөөмийн “Амьсгааны хаан” чимэг | 2000 |
| 8 | Монгол Улсынхаа 3 хот, 21 аймаг, 300 гаруй суманд, 1500 гаруй удаагийн тоглолтод, 500000 гаруй үзэгч | 1981-2008 |
| 9 | ХБНСЮУ, БНСУ, БНАСАУ, БНСВУ, БНАААУ, БНАЛАУ, Камбожийн Хаант Улс, Япон Улс, ОХУ, Франц Улс, ХБНГУ зэрэг 20 гаруй оронд аялан тоглолт | 1981-2008 |
| 10 | Монгол Улсын Гавьяат Жүжигчин /МУГЖ/ | 2001 |
| 11 | Монгол Улсын “Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн Монголын Билэг авьяастнуудын Улсын жагсаалт”-д бүртгэгдсэн | 2012 |
| 12 | Засгийн газрын 475 тогтоол Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг шинэчлэн батлагдсан. | 2019 |

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын
2021 оны А/395 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт
Маягт № И-22

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ**
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**
**УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН**

2025 оны 04-р сарын
28-ны өдөр

Дугаар CVL2585010001001217

Увс - Улаангом

## НАС БАРСНЫ БҮРТГЭЛИЙН ЛАВЛАГАА

| | | | |
|---|---|---|---|
| Иргэний харьяалал: | ***Монгол*** | **Нас барсан он, сар, өдөр:** | ***2025-03-01*** |
| Регистрийн дугаар: | ***оэ57050314*** | Бүртгэсэн газар: | **Увс Улаангом** |
| Иргэний бүртгэлийн дугаар: | ***850133071954*** | Бүртгэлийн дугаар: | ***0034*** |
| Овог: | ***Шарнууд*** | Бүртгэсэн он, сар, өдөр: | ***2025-03-06*** |
| Эцэг /эх/-ийн нэр: | ***Эжээ*** | | |
| Өөрийн нэр: | ***Тойвгоо*** | | |
| Хүйс: | ***Эрэгтэй*** | | |

Улсын бүртгэгч
*(албан тушаал, тэмдэг)*

УВС АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БҮРТГЭГЧ
И/П-23

........................................
*(гарын үсэг)*

**Б.Алтнаа**
(гарын үсгийн тайлал)

**СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ СУРТАЛЧЛАН АЛДАРШУУЛАХ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХЭД ОНЦГОЙ ХУВЬ НЭМЭР ОРУУЛСАН ӨВЛӨН УЛАМЖЛАГЧИД НЭР ДЭВШИГЧ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЭЖЭЭ ОВОГТОЙ ТОЙВГООГИЙН МАТЕРИАЛЫН ХАВСРАЛТ БАРИМТУУД**

**Үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээнд гаргасан амжилтууд:**

**БНАСАУ-ын Пхеньян хотын Хаврын баяр урлагийн наадмаас Алтан медаль хүртсэн 1987 он**






**Вьетнам улсын Хошимо хотын хүндэт иргэн, соёлын тэргүүний ажилтан цол 1987 он**


CỘNG HÒA XÃ HỘI CHỦ NGHĨA VIỆT NAM
Độc lập — Tự do — Hạnh phúc

HUY CHƯƠNG CHIẾN SĨ VĂN HÓA

BỘ VĂN HÓA VÀ THÔNG TIN

Tặng Đ/c Ejeguiin Toivgoo
Chức vụ Đoàn đại biểu Văn hoá
Đơn vị công tác Nước CHND Mông cổ
Theo quyết định số 734 VH-QĐ

Ngày 10 tháng 10 năm 1987

Số 734

**Монгол улсын гавьяат жүжигчин цолны үнэмлэх 2001 он**


№ 1393

Эжээгийн
Тойвгоо
Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2001 оны 7 сарын 5 ны
өдрийн 11 дүгээр
зарлигаар Монгол Улсын
гавьяат
жүжигчин
цол хүртээв.

Монгол Улсын Ерөнхийлөгч
Нацагийн БАГАБАНДИ

**“Монгол хөөмэй” холбооноос битүү амьсгааны хаан хэмээн өргөмжлөгдөж мэргэжлийн хөөмийчнөө үнэмлэх 2001 он**




**Бүгд найрамдах Тыва улсын ардын урлагийн наадмын шилдэг үзүүлбэр, тэргүүн байр 1981 он**



Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав Улс (ХБНСЮУ), Бүгд найрамдах Солонгос улс (БНСУ) буюу Өмнөд Солонгос, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (БНАСАУ) буюу Умард Солонгос, Вьетнам, Алжир, Япон, ОХУ, Югослав, Франц, Финланд, Герман зэрэг дэлхийн 20 гаруй орноор монголын бие бус өвийг Уралдаан тэмцээн болон аядан тоглолтоор явсан.





Франц улсад тоглолтын үеэр 2003 он



## Оросын холбооны улс-1990 он





**Оросын холбооны улс-1990 он**



Югослав улс-1991 он



Алжир улсад тоглолтын үеэр-1984 он



Япон улсад тоглолтын улсад 1992он






Герман улсад “Алтай хайрхан хамтлаг”-2004 он



**Сургалт:**



**Шавь нарын хамт 2009 он**



**Ховд аймаг “Хөөмийчдийн наадам” Шавь Лхагва, О.Отгонхүү нар-2003 он**



**Шавь Ж.Зундуйн хамт 2010 он**



**Шавь Л.Лхамрагчаатай хамт-2023 он**



2014 оноос Боловсролын соёл урлагийн газартай хамтран Ерөнхий боловсролын сургуулиудад шавь сургалт зохион байгуулж байна. Сургалтад Увс аймгийн Өлгий, Зүүнговь, Ерөнхий боловсролын 2,3 дугаар сургуулийн 120 гаруй сурагчид хамрагдсан байна.





**Ерөнхий боловролын 2 дугаар сургуулийн сурагч шавь нарын хамт- 2022 он**





**Ерөнхий боловролын 3 дугаар сургуулийн сурагч шавь нарын хамт- 2023 он**







СЭЭР НУРУУГҮЙТЭН
НАВЧНЫ ГАДААД
ҮЗҮҮР
ИЛТЭС
ДАГАВАР
СУУРЬ
БАРИУ
БҮТЭЦ
гадаад
бүтэц





## Хамтран ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт


**УВС АЙМАГ**
**ЗҮҮНГОВЬ СУМЫН ЕРӨНХИЙ**
**БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ**

Зэлийн гол, Зүүнговь сум, Увс аймаг, 85040
Цахим шуудан: zuungovi@edu.uv.gov.mn


2022. 12. 22 № 43

танай ____________ -ны № ____________ -т

Тодорхойлолт

Монгол Улсын Гавьяат жиүжигчин Эжээ овогтой Тойвгоо нь манай сургуулийн сурагч багачуудад 2019 оны 09 дугаар сард Соёлын биет бус өвийн сургалт явуулж улмаар 33 сурагчид магтаал, хөөмий зааж соёлын биет бус өвийг эзэмшигч, сонирхогчдын тоог нэмэгдүүлсэн.

ЗАХИРАЛ Б.АНХБАЯР

8518262260 9062815

УВС АЙМАГ
УЛААНГОМ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 3 ДУГААР СУРГУУЛЬ
10 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85177
Утас: 7045-3033
Цахим шуудан: ahlah3@edu.uv.gov.mn

2023.12.18 № 114

танай ___________ -ны № ______________ -т

ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын гавьяат жүжигчин Эжээ овогтой Тойвгоо нь манай сургуулийн сурагчдад 2023 оны 11 дүгээр сард соёлын биет бус өвийн сургалт явуулж улмаар 25 сурагчид магтаал, хөөмэй зааж соёлын биет бус өвийг эзэмшигч сонирхогчдын тоог нэмэгдүүллээ.

ЗАХИРАЛ Х. ОРШИХ

---

УВС АЙМАГ
ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ
Хар ус, Өлгий сум, Увс аймаг, 85150
Цахим шуудан: ulgii@edu.uv.gov.mn

2022.12.23 № 53

танай ___________ -ны № ______________ -т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Монгол Улсын гавьяат жүжигчин Эжээгийн Тойвгоо нь тус сургуульд 2019 оны 02 сард хөөмийн сургалт явуулсан. Уг сургалтад 150 хүүхэд хамрагдаж, хөөмий урлагийг сонирхож буй хүүхэд залуусыг идэвхжүүлсэн.

Сургалтын үр дүнд манай сургуулийн төгсөгч Р.Батзул нь хөөмийч мэргэжил эзэмшихээр Завханы аймгийн СУИС-ийн Завхан дахь салбар сургуульд суралцаж байна.

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МӨНХБАЯР

8522650023

**Хөөмийн судлалын чиглэлээр ирсэн гадаад дотоодын судлаачидтай 2000 оноос одоог хүртэл хамрагдсан ажиллаж байна:**









BIKKEMBERGS
1 5G

**Шавь Ж.Зундуй, Японы хөөмий судлаачдын хамт**



**Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны "Талархал" хүртэж байсан.**



Соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр гадаад, дотоодод зохион байгуулагдсан үйл ажиллагаануудад Монгол улсаа төлөөлөн оролцож олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгч байсан.

БНАСАУ-ын Пхеньян хотын Хаврын баяр нөхөрлөлийн урлагийн наадмын хэвлэл 1987 он







Бүгд найрамдах Финланд улсын сонин 1990 он 4 сарын 19


Reisjärvi

Mongolialainen taiteilijaryhmä esiintyi kuntalaisille

**Соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулан "Алтай хайрхан" нэртэй CD гаргасан мөн өөрийн оролцсон нэвтрүүлэг болон бичлэгийг олон нийтийн youtube болон facebook сувгуудад тавьж залуу хойч үедээ хүргэж байна. доорх линкээр орж сонирхоно уу:**




- (82) E. Toivgoo - Э. Тойвгоо / An Anthology of Mongolian Khцcmii - Монгол Хөөмийн Сонгомол - YouTube
- (82) Naaraan suutn E Toivgoo 2016 - YouTube
- https://www.facebook.com/enkhlen.pagvajav/videos/1478539272236152
- https://www.youtube.com/watch?v=falpaobJfh0

**Соёлын биет бус өв болох хөөмийг 600 гаруй шавьдаа зааж сурган, хойч үедээ түгээн дэлгэрүүлсээр байна. Шавь нараас нь дурдвал: МУСТА Л.Лхамрагчаа, МУСТА Д.Басан, О.Отгонхүү, А.Лхагва, Ж.Зундуй нар юм. Шавь нарын урын санг доорх линкээр орж сонирхоно уу.**

- (82) O. Otgonkhьь - О. Отгонхүү / An Anthology of Mongolian Khццmii - Монгол Хөөмийн Сонгомол - YouTube
- (82) Хөөмийч Л.Лхамрагчаа - "Жангар" тууль - YouTube
- (82) Таван тэсийн магтаал | Хөөмийч Д.Басан | Ойрад театр | Бидний цөөхөн Монголчууд - YouTube

**Шавь нарын хамт:**







**Францад хөөмий сонирхогчдын хамт-2005 он**



